



MFWA

МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН
САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ

**МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ
НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
БАРИМТЛАХ БОДЛОГО**

Удирдах зөвлөлийн 2016 оны 10 сарын 29-ний
өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Оршил

1.1 Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг нь (цаашид МГБССН гэх) Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны (ОУГБТХ-ны) жинхэнэ гишүүн нийгэмлэгийн хувьд хүний эрхийн болоод үнэт зүйлийн асуудалтай уялдсан, өөрийн үйл ажиллагаанд баримтлах бодлоготой байж энэхүү нэгдсэн бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулах, хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

1.2 Нийгэмлэг нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ нийгэмлэгийн холбогдох дүрэм, журамд тусган хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хоёр. Нийгэмлэгийн бодлого

2.1 Ажлын байран дахь ХДХВ/ДОХ-ын талаар баримтлах бодлого

МГБССН нь ХДХВ-ийн халдвартай ажилтаныг ажлын таатай нөхцөлөөр хангаж дэмжиж ажиллана. ХДХВ-ын халдвартай болон халдвар авах эмзэг байдлын улмаас ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохын эсрэг байр суурийг баримталж ажиллана.

2.2 Эрсдлийн удирдлагын бодлого

Нийгэмлэг нь байгууллагын стратеги, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх явцад гарч болох сөрөг нөлөө түүний үр дагаврыг тооцож дүн шинжилгээ ба үнэлгээ хийж, гарч болох сөрөг нөлөө түүний шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, эрсдэл үр дагаварыг арилгах, бууруулах, даван туулах үр дүнтэй удирдан зохион байгуулахад чиглэгдсэн хариу арга хэмжээ авч ажиллана.

Энэ нь эрсдлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хянах ба холбоо харилцаа тогтоох гээд тасралтгүй үйл явц бөгөөд үүн дээр үндэслэн Нийгэмлэг үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

2.3 Үр хөндөлтийн талаар баримтлах бодлого

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд аюултай үр хөндөлтийн тоог бууруулан үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлана.

2.4 Нөөцийг бүрдүүлэх бодлого

Нийгэмлэг, түүний бүх гишүүд төсөл хөтөлбөрүүдтэй хамааралтай нөөцийг бий болгох үйл ажиллагааг боловсруулж, төсөл хөтөлбөрүүдийн хүрээг тэлж тогтвортой, хүртээмжтэй байдлыг сайжруулах бодлогыг баримтлан ажиллана.

2.5 Хяналт шинжилгээ, үнэлгээний талаар баримтлах бодлого

Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг хүн бүрт чанартай, хүртээмжтэй хүргэж, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлж, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, улмаар эхчүүд эмэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулах ажлын гүйцэтгэл, чанарыг хянаж, үнэлэн шаардлагатай зөвлөмжөөр хангах, үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах бодлогыг баримтлана.

2.6 Мэдээлэл хуваалцах, хэвлэл нийтлэлийн талаар баримтлах бодлого

Нийгэмлэг нь Монгол улсын хууль тогтоомж болон эрхэм зорилго, стратеги, бодлого, дүрэмтэй нийцсэн мэдээллийг оролцогч талууд болон нийтэд түгээнэ.

2.7 Жендэрийн тэгш байдалын талаар баримтлах бодлого

Нийгэмлэг нь гишүүний хувьд жендэрийн тэгш байдалдыг мөрдлөг болгож, эмэгтэйчүүдийн чадавхийг дээшлүүлэх, тэднийг шийдвэр гаргах түвшинд тэгш эрхтэйгээр оролцуулах, нийгэм-эдийн засгийн бүх түвшинд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхийг зорьж ажиллана.

2.8 Хүүхэд, залуучуудын эрхийг хамгаалах талаар баримтлах бодлого

Нийгэмлэг нь үйл ажиллагаандаа хүүхэд залуучуудын оролцоог хангах, хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих, хамгаалах, дэмжих бодлогыг баримтлан ажиллана.

2.9 Өсвөр үе, залуучуудын талаар баримтлах бодлого

Өсвөр үе, залуучуудын нас, хүйс, онцлог, хэрэгцээнд нийцсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн амьдралын эрхийн мэдлэг, боловсрол, цогц тусламж үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран чанартай хүртээмжтэй үзүүлэх бодлогыг баримтлана.

2.10 Үйлчилгээний хүртээмжийн талаар баримтлах бодлого

Нийгэмлэг нь бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай, цогц тусламж үйлчилгээг бэлгийн ба нөхөн үржихүйн эрхийг ханган нас, хүйс, яс үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал, боловсролын түвшин, бэлгийн чиг хандлага, газарзүйн байршлаас үл хамааран тэгш хүртээмжтэйгээр үзүүлэх бодлогыг баримтлана.

2.11 Санхүүгийн луйвар, залилан мэхлэх байдлаас сэргийлэх тухай бодлого

Нийгэмлэг нь үйл ажиллагаандаа санхүүгийн луйвар, залилан хуурамч байдлаас сэргийлэх талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд авах бөгөөд санхүүгийн луйвар, залилан мэхлэх явдалтай тэмцэхэд төрийн болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх бодлогыг баримтлана.

2.12 Байгаль орчин, хог хаягдлын бодлого

Нийгэмлэг нь үйл ажиллагаандаа Байгаль хамгаалахтай холбоотой Монгол улсын хууль тогтоомжийг баримтлах бөгөөд үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд хохирол багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэх дэмжлэг үзүүлэх бодлогыг баримтлана.

2.13 Хувийн компанитай хамтарч ажиллах нийгмийн хариуцлага биелүүлэх бодлого

Нийгэмлэг нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллахдаа харилцан үр ашигтай талуудын эрх тэгш байр суурыг хадгалах, нийгэмлэгийн эрхэм зорилго зарчимд нийцүүлэн зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах бодлогыг баримтлана.

2.14 Ухуулга нөлөөллийн бодлого

Нийгэмлэг нь өөрийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн нийтийн бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг олгоход чиглэгдсэн ухууллага нөлөөллийг зорилтод бүлгэд тэгш, хүртээмжтэй хүргэх бодлогыг баримтлана.

2.16 Хамтын ажиллагааны бодлого

Нийгэмлэг нь Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны (ОУГБТХ-ны) жинхэнэ гишүүн нийгэмлэгийн хувьд эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд Төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшилтэй тэгш эрхийн хүрээнд, хууль тогтоомжид нийцүүлэн, үр дүнд суурилсан зарчмын дагуу хамтран ажиллах бодлогыг баримтлана.